## ГЕОПОЛИТИК, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

# КОНЦЕПЦИЯ «МЯГКОЙ СИЛЫ»: ОБЗОР ПОДХОДОВ В ЗАРУБЕЖНОЙ НАУКЕ

**А.В. МИХАЛЕВ**[1]
*Доктор политических наук, доцент,*
*Бурятский госуниверстетет*

Буриадын Улсын их сургуулийн доцент А.В.Михалевийн "Зөөлөн хүчний" үзэл баримтлал сэдэвт өгүүллийн товч хураангуй: "Зөөлөн хүчний" үзэл баримтлалын асуудал өнөө хэр нэг мөр томьёологдоогүй ч улс төрийн харилцааны практикт аль эртнээс хэрэгжиж ирсэн түүхтэйг Ази, Европын улс орнуудын улс төрийн бодлогын жишээг үлгэр болгон авч үзжээ. "Зөөлөн хүч" хэмээх нэр томьёог Ж.Най 1990-ээд онд улс төрийн шинжлэх ухааны эргэлтэнд оруулсан хэдий ч түүний үзэл санааны эх суурь Х.Моргентау, К.Кнорр, Р.Клайн зэрэг барууны судлаачдын бүтээлүүдэд тусгагдсан байдаг байна. "Зөөлөн хүч" нь улс төрийн аливаа том, жижиг зорилгыг хэрэгжүүлэхэд цэрэг,зэвсгийн хүч чадалд дулдуйдахаасаа илүүтэй засаглалын материаллаг бус нөөц болох санал, зөвшилцөөнд суурилсан дипломатын бодлого, үндэсний өөрийн ухамсар, засгийн газрын чадамж, үндэсний зан чанар гэх мэт санаа бодолд түшиглэсэн засаглалын аргаар "Шинэ том тоглоомд" стратегийн зорилтуудыг шийдвэрлэх зэвсэг гэж үзэж болно. Ингэхлээр зөөлөн хүч бол явцуу утгаараа соёлын нөлөөлөлтэй төстэй ажгуу. Харин өргөн утгаар нь үзвэл аливаа улс төрийн асуудлыг цэрэг, зэвсгийн бус, соёлын болон эдийн засгийн хүчин зүйлсийн тусламжтайгаар энхийн аргаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлдэгээрээ онцлог юм. Тиймээс улс төрийн институциуд зөөлөн хүчний бодлогыг хэрэглэх замаар өмнөө тавьсан зорилго, зорилтыг шийдвэрлэхийг хичээх болжээ[2].

Мягкая сила, является продуктом довольно запутанной концепции. Дж. Най не дал ей простого определения[3]. Вместо этого он дает множество дефиниций:

1) Как способность формировать предпочтения других;
2) Как способность привлекать, и эта привлекательность часто происходит с молчаливого согласия;
3) Как способность заставить других хотеть того же результата, что хотите и вы из-за обращения в вашу культуру и идеологию;
4) Как способность стран получать желаемые результаты в мировой политике, потому что другие страны наблюдают их достижения, подражают их примеру, стремятся к уровню процветания и открытости, желая достичь его;
5) Как ключевой элемент управления, как способность притягивать (заставить) других хотеть того, чего хотите вы, формировать запросы, устанавливающие повестку дня.

Хотя Дж. Най ввел термин в 1990 г., концепция мягкой силы берет свое начало в работах Х. Моргентау, К. Кнорр и Р. Клайн. Например, Моргентау выделяет девять элементов национальной мощи, среди которых национальный характер, национальное самосознание, качество дипломатии и качество правительства, тесно связанные с нематериальными источниками власти, то есть с мягкой силой. Аналогично Карр пишет, что власть над мнениями имеет не менее важное значение для политических целей, чем военная и экономическая мощь, хотя и коррелируется с ними. Согласно Равену и Френчу, существует пять основ власти: награды, принуждение, законны, референты и эксперты. Мягкая сила является своего рода референтом власти, которая основана на притягательности, и определяет влияние в отношении других держав. Доводы в подтверждение концепции мягкой силы можно проследить в философии на протяжении более, чем двух тысяч лет. В древнем Китае, мягкая сила воспринимается сильнее и мощнее, чем жесткая власть, особенно наглядно они представлены в книге Сунь Цзы. Так, например, Б. Маттерн считает, что вряд ли Най был первым, кто раскрыл сущность власти вне контекста угроз или обещаний. Такие мыслители как Фуко, Бурдье, Грамши и другие придавали схожие значение власти, однако, так и не сформулировали понятие «мягкой силы» [6, с.3]. Понимание этого феномена тесно связано с пониманием власти, предложенным перечисленными авторами, однако, прямой корреляции между ними нет. Концепция Дж. Ная является оригинальной теорией, вокруг которой

[1] Михалев Алексей Викторович – доктор политических наук, доцент, Бурятский госуниверстетет (670000 Россия, Улан-Удэ, ул. Смолина 24а, mihalew80@mail.ru).
[2] Г.Цэнд-Аюуш. – доктор политических наук, профессор Монгу
[3] Концепция мягкой силы была задумана им как поправка к американской внешней политике, которая стала слишком зациклена на американском военном превосходстве в посткоммунистическом мире, где США являются единственной реальной сверхдержавой (в формате «жесткой силы»).

ведутся дискуссии по сей день уже в силу того, что она раскрывает новые грани понимания власти, являющейся ключевой категорией в политической науке.

Мягкая сила это инструмент, благодаря которому достигаются стратегические задачи Новой Большой игры. Оно базируется на трех основных ресурсах: ее культуре, ее политических ценностях и внешней политике (когда она рассматривается как легитимная, имеющая моральный авторитет). Как указывает Дж. Най в своей статье «Подумайте еще раз: мягкая сила», термин «растягивается» и становится все более «раскрученным». Популярное понимание этой концепции существует как в более узком смысле, так и в более широком смысле. В более узком смысле, мягкая сила похожа на культурное влияние. Яркими сторонниками данной трактовки принято считать британского историка Найла Фергюсона и немецкого публициста Йозефа Йоффе[4]. Большинство научных школ о мягкой силе в Китае разделяют понимание этого концепта в узком смысле. В более широком смысле, мягкая сила является синонимом невоенной силы и включает в себя и культурную силу, и экономическую мощь. В то время как эти популярные понимания порождают недоразумения, возникает вопрос о том, почему они пользуются популярностью и столь устойчивы. Следует отметить, что концепция была неправильно понята не только широкой публикой, но и экспертами по исследованию международной политики. Сущность этого непонимания кроется в смешении категорий «мягкая сила» и «ресурсы для мягкой силы». Во многом эти проблемы связаны со слабой разработанностью аналитического инструментария данной концепции.

Теория Дж. Ная имеет большое количество критиков. Так, например, Стивен Льюкс (автор работы «Власть: радикальный взгляд») называет подход Ная «агенто-центрированным стратегическим» взглядом на власть и критикует его как «тупой инструмент». Автор отмечает что, Наю не удалось сделать различия между различными способами, при которых мягкая сила может кооптировать, привлечь и побудить тех, кто подвергается ее воздействию, и между различными способами, в которых она может вызвать лишь их молчаливое согласие. Он не проводит различия между режимами убеждения и способами формирования предпочтений [6, с.17]. Данная дискуссия свидетельствует о том, что две современные теории «власти-силы» соперничают за право быть эффективными инструментами политического анализа. Споры вокруг понятия мягкая сила и его неолиберального содержания занимают важное место в современной политической науке. Вопрос о том, возможна ли власть (сила), не опирающаяся на принуждение, насилие или манипуляцию, по сей день остается открытым.

На уровне теории мягкая сила рассматривается, в том числе и как способность создавать искаженную картину мира, вынуждая актора, на которого оказывается данное воздействие, принимать политические решения, выгодные тому, кто применил в его отношении не мягкую силу. По мнению Дж. Галларотти, подобное понимание мягкой силы близко к концепции А. Грамши о гегемонии и теории третьего лица власти С. Льюкса. Все это формирует еще одно, зачастую критикуемое, основание мягкой силы – ложное сознание. Использование данной категории предполагает, что ложное сознание неявно формируется одной господствующей нацией у другой подчиненной. В идеале либеральной теории предполагается, что мягкая сила дает выбор идеологий и образов тому, на кого она направлена. Последние должны лишь выбрать самого комплементарного союзника и самую приемлемую идеологию. Однако практика показывает, что это невозможно, поскольку принятие подобных решений бывает либо авторитарным, либо опирается на заблуждение. В итоге, мягкая сила перестает быть либеральным инструментом воздействия уже потому, что в ней изначально присутствует конфликт интересов и элемент манипуляции.

В данной ситуации также важно развести термины силы (власти) и доминирования. Первое предполагает собой некий консенсус и взаимную выгоду, пусть и основанную временами на неравноправном обмене. Доминирование же приходит через столкновение и конфликт интересов и предполагает подчинение одних другим. Так, Дж. Галларотти считает, что мягкая сила связана с теорией М. Фуко, в основе которой все тот же конфликт интересов. При этом, по мнению Галларотти, специфика мягкой силы зачастую заключается в умении доминантной нации выдавать свои интересы как интересы стран, на которые оказывается влияние [2, с.62]. Наряду с этим, институты, реализующие данную политику, могут обладать определенной степенью автономии.

Данный автор считает: «Склонность великих или доминантных держав интенсивно вкладывать средства в создание режимов и международных организаций заставляет полагать, что такие рычаги влияния поистине важны для этих наций. То, что такие институты поддерживаются нациями, наделенными большей независимостью, побуждает считать, что они все еще служат ряду целей в интересах доминантных наций: обеспечение законности, защита репутации, ограждение от помех, с какими сопряжена односторонность, различные способы облегчения функционирования рынков. К

[4] При этом, оба являются критиками концепции мягкой силы.

тому же, поскольку эти институты устроены с размахом и поддерживаются могущественными нациями, они зачастую выполняют дополнительные функции в интересах самих наций. Но так как эти институты принимают более многостороннюю властную структуру (т.е. в эволюции управления действует демократический импульс), часто их функции могут отклоняться от интересов тех могущественных наций, которые их создали» [2].

Другой важной рефлексией по поводу мягкой силы является китайская школа изучения данного феномена. Начиная с 2003 года, руководство КНР в лице ЦК КПК занялись разработкой концепции, обосновывающей место Китая в современном мире. Согласно исследованию О. Борох и А. Ломанова, китайская идеология внешнего присутствия претерпела несколько трансформаций от модели «мирного возвышения» и «мирного развития» к концепции «гармоничного мира совместного процветания», предложенной лично Ху Цзиньтао [1]. Как пишет Юй Кэпин, выдвигая идею «гармоничного мира», китайское правительство исходило из того, что к такому ценностному идеалу стремится все человечество, а «мир и развитие, как две великие темы современности, являются важнейшим содержанием строительства гармоничного мира». При этом, по мере углубления экономической глобализации интересы государств и народов будут становиться все более многоплановыми, политика – более многополярной, культура – более многообразной. Следовательно, подчеркивает китайский политолог, между странами и народами все более будут востребованы взаимная терпимость и уважение, мирное сосуществование, реализация древнекитайского идеала «единства без унификации» [1, с.44].

Современные китайские теоретики большое внимание уделяют изучению феномена мягкой силы и его практического применения. Сегодня можно уже говорить о том, что в мире сложилась китайская школа изучения данного феномена. Работая в крупнейших мировых центрах по изучению мировых политических процессов, китайские исследователи предлагают свои направления данного анализа, ориентированные на достаточно специфический материал Африки и Юго-Восточной Азии. Примерами тому могут быть исследования таких ученых как Чанфенг Чен, Ёнгжин Чжан, Ли Минжанг, Ю Хинтиан, Янджонг Хуан и другие.

Критикуя западную теорию мягкой силы, профессор Ёнгжин Чжан пишет: «Судя по стандартному рейтингу Ная, Китай вряд ли может претендовать на ресурсы мягкой силы. Нынешняя политическая система Китая отличается от Соединенных Штатов. Китай всегда имеет "ужасный рейтинг" в опросе Freedom House, даже среди наименее свободных стран в мире. Пекин открыто отвергает "западные" либерально-демократические ценности, и китайское государство часто рассматривается как лицо, нарушающее права человека в собственном доме. С трудом просматриваются политические ценности и идеологические убеждения Китая. Пекин либо проповедует, либо практикует универсальную привлекательность. В отличие от Европейского Союза, китайская политика и подходы к глобальным проблемам, начиная от изменения климата и охраны окружающей среды, заканчивая пандемией и инфекционными заболеваниями, страдают отсутствием морального авторитета» [7, с.50].

Указывая несправедливость данной точки зрения, китайский исследователь указывает на то, что обаяние Китая в Европе и в США в разное время колебалось от нулевой отметки до массового увлечения китайской культурой. Он считает, что ключевым понятием мягкой силы должен стать концепт, характеризующий ее потенциал, опирающийся на историко-культурные традиции ведения дипломатии. Потенциал мягкой силы, согласно китайской академической традиции, – это некая исторически сформированная репутация страны, ориентирующая ее внешних партнеров на формирование двустороннего диалога в рамках сложившихся норм и традиций. Ёнгжина Чжана поддерживает и китайский исследователь Янг Фан: «Нельзя отрицать, что в то время как американцы наблюдают снижение своей мягкой силы, китайская мягкая сила в настоящее время на подъеме, в первую очередь в Юго-Восточной Азии, а также в Африке и Латинской Америке. Образ китайской нации в развивающихся странах, особенно в Африке, гораздо более позитивен, чем на Западе. Примером тому, "Пекинский консенсус", термин, введенный Дж. Рамо, объясняющий популярность китайской модели экономического развития, которая по мнению большинства развивающихся стран является жизнеспособной альтернативой западной модели».

Помимо этого, существует еще и дилемма оценки эффективности мягкой силы. Так, А. Вьювинг считает: «Оценивая чью-либо силу, мы замеряем количество ресурсов, которыми этот кто-то располагает. Это делает мягкую силу более конкретной и измеряемой. Однако это не единственная важная причина, почему силу часто определяют в категориях ресурсов ее обладателя. Другим аспектом этой тенденции является тот факт, что никакая власть не может осуществляться без использования определенного количества ресурсов» [6, с.11]. Анализируя указанную ситуацию, А. Вьювинг высказывает мнение о том, что теория мягкой силы требует более подробной доработки, особенно в сфере категориального

аппарата. Согласно его мнению, это позволит избежать существующей путаницы, связанной с тем, что такое мягкая сила, что является ее ресурсом, а что ее институтом.

Мягкая сила – это способность достигать желаемых результатов за счет привлечения, а не принуждения, она стала важной частью научного мышления. Основным компонентом мягкой силы является притягательность, которой в значительной степени пренебрегали в научных исследованиях. Проводившиеся исследования предлагали варианты данной политики и этические выводы о мягкой силе, распространяемые на всех на основе неявных и часто неподтвержденных предположений о том, что такое привлекательность. Как утверждает Б. Маттерн: «Привлекательность в мировой политике достигает через нефизические, но все же принудительные формы власти, которые осуществляются посредством языка. Поэтому мягкая сила не должна пониматься через сопоставление с жесткой силой, а скорее как ее продолжение другими способами». Российский исследователь К.И. Косачев считает: «"Мягкая сила" далеко не всегда связана с размерами, экономической или военной мощью, идеологией государства. Можно, например, быть лидером по средней продолжительности жизни своих граждан, по уровню заработной платы и пенсий, по рейтингам ведения бизнеса, по надежности национальной валюты, по экологическим стандартам, по уровню и доступности образования, по длительности существования государства без войн и катастроф и многим другим параметрам, которые составляют авторитет и репутацию страны в глазах других народов. И здесь малые очень часто выигрывают у больших по многим показателям» [3].

С данным мнением не согласен китайский политолог Ли Минджанг: «Однако логически непонятно, почему культура, идеология и ценности должны быть источниками мягкой силы. Такой вывод, очевидно, основан на предположении, что эти источники влияния по своей природе привлекательны, убедительны и естественно вызывают симпатии. Но на самом деле это не всегда может быть так. С одной стороны, эти источники мягкой силы не всегда способствуют привлекательности, убеждению, апелляции и подражанию. Культура, идеология, ценности и нормы также часто приводят к обидам, отторжению, враждебности и даже конфликтам. С другой стороны, жесткая сила не всегда используются для принуждения, угроз, и запугивания» [5, с.3]. Данные рассуждения ставят в эпистемологический тупик динамично развивающуюся теорию Дж. Ная. Однако именно азиатские теоретики наиболее подробно разобрали ее недостатки и предложили собственные интерпретации.

Однако анализировать сам процесс мягкого влияния практически невозможно, в этом случае гораздо эффективнее, институциональный анализ. Дело в том, что институты практически всегда на виду, все остальное находится в сфере сознания и в области мотивов и побудителей к действию отдельных индивидов или политической элиты в целом. В рамках данного исследования нами анализируется институциональная составляющая мягкой силы. Институты мягкой силы – это то, посредством чего она формируется, а также то, посредством чего можно оценить потенциал мягкой силы того или иного государства. Однако относить их к потенциалу было бы не правильно, т.к. потенциал мягкой силы – это определенная система презентаций, смыслов и историко-культурного наследия. Институты же служат инструментом для трансляции данных составляющих, формируя политику мягкого влияния как некий феномен. Институты во многом устанавливают нормы понимания задач, которые предполагается достичь посредством мягкой силы. Вопрос о том насколько широкой или напротив узкоспециальной будет трактовка того или иного образа, культурного кода, идеологического концепта определяется институтами soft power.

**Литература**


1. Борох О., Ломанов А. Скромное обаяние Китая / О. Борох, А. Ломанов // Pro et Contra. – 2007. – №6 (39). – С.41-60.
2. Галларотти Дж. Бремя могущества как парадокс мировой политики / Дж. Галларотти // Полис. 2011. №3. С. 58-71.
3. Косачев К.И. «Мягкая сила» и европейское измерение российской внешней политики // [Электронный ресурс] / Режим доступа: http://rs.gov.ru/sites/rs.gov.ru/files/brussel-zay.del.pdf
4. Най Дж. С. Гибкая власть. Как добиться успеха в мировой политике / Дж. С. Най. – М., Новосибирск: «Тренды», 2006. – 224 с.
5. Li Mingjiang Introduction: Soft power: Nurture not Nature / Li Mingjiang // Soft power. China's Emerging Strategy in International Politics. New York: Lexington books. 2009. P. 3-25.
6. Vuving A. L. How soft power works / A. L. Vuving // American Political Science Association annual meeting. Toronto, September 3. 2009. P.1-20.
7. Yongjing Zhang The Discourse of China's soft power and its Discontents / Yongjing Zhang // Soft power. China's Emerging Strategy in International Politics. New York: Lexington books. 2009. P.45-60

# МОНГОЛ СОЛОНГОСЫН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦААНЫ ТОЙМ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

**ПАК ЧУН ЧОЛ**
*Профессор. Кёнсан Үндэсний Их Сургуулийн*
*Нийгэм Судлалын Сургууль*
**С.ОЮУНЦЭЦЭГ**
*Докторант. Кёнсан Үндэсний Их Сургуулийн*
*Нийгмийн Шинжлэх Ухааны Сургуулийн Олон Улсын Харилцааны Тэнхим*

**Түлхүүр үг:** Монгол Солонгосын харилцаа, гуравдахь хөршийн бодлого, Умардын бодлого, харилцааг хэвийн болгох, түншлэлийн харилцаа, халлю

**Хураангуй:** Монгол, Солонгос хоёр улс нь дипломат харилцаа тогтоосны дараа харилцан нөхөх байдлыг үндэсээ болгосон нягт хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн. Монгол Улсад Халлю буюу Солонгосын соёлын урсгал хүчтэй дэлгэрч байгаа бөгөөд Солонгосыг Солонгос (Солонгын орон), ээжийн орон, худ ургийн орон зэргээр ойр дотноор дууддаг. Энэхүү судалгаа нь Монгол, Солонгосын харилцааны өнгөрсөн болон өнөөгийн байдлын талаарх шинжилгээ хийх зорилготой юм.

**Abstract:** Based on historical, ethnic, linguistic and cultural similarity and complementary relationship in politics, security, economy, resource development and culture, Korea and Mongolia have perceived each other as companions. In Mongolia, the Korean Wave is at high tide and it friendly calls Korea as Solongos, a mother country and a country in-law.

This study is to recollect the twenty-year relationship of Korea and Mongolia since their diplomatic normalization and to explore the current situation of the relationship in comprehensive and introductory way. With the demise of the Cold War in the late 1980s, the two nations made approaches to each other. Mongolia's 'Third Neighbor Policy', first formulated during the presidency of Punsalmaagiin Ochirbat and President Roh TaeWoo's 'Nordic Policy' attained the diplomatic normalization of Korea and Mongolia in March 1990. Subsequently, President Kim DaeJung's 'Sunshine Policy' and resource diplomacy enhanced the cooperation with Mongolia and, in April 1999, Kim and President Natsgaiin Bagabandi declared 'Mutually Complementary and Cooperative Relationship in the 21st Century,' which yielded the elevation of the Korea-Mongolia relation after the nine years since the normalization. The Korean Wave which has enjoyed its popularity since the early 2000s has contributed in promoting the reciprocal friendship. In May 2006, Presidents Roh MooHyun and Nambaryn Enkhbayar declared 'Partners of Good Neighborliness, Friendship and Cooperation,' and Presidents Lee MyungBak and Tsakhiagiin Elbegdorj endorsed 'Comprehensive Partnership.'

Nonetheless, in spite of the 2011 declaration, Korea and Mongolia still fail to make a more enhanced relationship beyond the frame of the 1999 one. From a big picture perspective, the two countries should aim to form creative and multi-dimensional interdependence.

1980-аад оны сүүлчээр хүйтэн дайны дараах таатай нөхцөл байдлыг ашиглан Өмнөд Солонгос, Монгол хоёр улс нь харилцан бие биедээ ойртож эхэлсэн. Очирбат Ерөнхийлөгч гуравдахь хөршийн бодлого, Ну Тэ Ү Умардын бодлогыг явуулсаны үр дүнд 1990 оны 3 дугаар сард хоёр тал нь харилцаа тогтоож чадсан. Ким Дэ Жун Ерөнхийлөгч нь Нарны илч бодлого болон нөөц баялагийн гадаад бодлогыг явуулснаар Монголтой харилцаагаа бэхжүүлсэн ба 1999 оны 4 дүгээр сард Багабанди Ерөнхийлөгчтэй харилцан нөхсөн хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлэхээр тунхагласан. 2000 оны эхний хагасаас эхлэн Халлюгийн моод дэлгэрч, үүнтэй зэрэгцэн Монголчуудын зүгээс Солонгост суралцах, ажиллах, Солонгос хүнтэй гэрлэх зэрэг явдал нэмэгдсэн нь харилцан найрамдалт харилцааг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ бүх харилцаан дээр тулгуурлан 2006 оны 5 сард Ну Мү Хён Ерөнхийлөгч, Энхбаяр Ерөнхийлөгч нар нь Сайн Хөршийн Найрамдалт харилцааг тунхагласан ба 2011 онд Ерөнхийлөгч И Мён Бак, Ерөнхийлөгч Элбэгдорж нар нь иж бүрэн түншлэлийн харилцааг хамтран тунхагласан.

Хоёр орны харилцаа нь тунхаглалын утга санааны дагуу тасралтгүй хөгжиж ирснийг үл харгалзвал 1999 оны хамтарсан тунхаглалын хэв загварыг давж гарсан харилцааг бий болгосон

хязгаар харагдаж байна. Жишээ нь Монголын нийгэмд Солонгост хүйтэн хөндий хандах асуудал маргаан болж байгаа хэвээр байна. Ерөнхийдөө урт удаан хугацааны нүдээр харвал Солонгос болон Монгол Улс нь бүтээлч, цогц харилцан түшсэн харилцааны хэлбэрийг бий болгоход хандах хэрэгтэй.

******

## I. ОРШИЛ

Монгол болон Солонгос нь түүх, угсаа, хэл, соёлын адил төстэй байдалтай зэрэгцээд улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, соёлын салбарт харилцан нөхсөн хамтын ажиллагааны зарчмыг үндсээ болгосон хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн.

Энэхүү судалгаандаа Монгол Улсын Гадаад Харилцааны Яам, Солонгосын Гадаад Харилцааны Яам, Монгол дахь Солонгосын Элчин Сайдын Яам зэрэг засгийн газрын байгууллагуудаас гаргасан материал болон Монгол Улсын ерөнхий нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл бүхий материалуудыг оруулсан. Солонгос, Монголын харилцаа нь түүх, гадаад харилцаа, улс төр, эдийн засаг, соёл зэрэг олон чиглэлээр хөндөгдөж байдаг ба ялангуяа эрдэс баялагийн хөгжил, хөрөнгө оруулалт зэрэг эдийн засгийн хамтын ажиллагаа болон нийгэм соёлын талаас судалгааны бүтээл их байдаг ч Монгол Солонгосын хойгийн харилцааг ерөнхийд нь шинжилсэн судалгааны бүтээл нь хуруу дарам цөөн.

Энэхүү өгүүлэл нь Монгол–Өмнөд Солонгосын хооронд харилцаа тогтоох үйл явц, түүний дараах өндөр дээд хэмжээний уулзалт, нийгэм соёлын харилцаанд чиглэсэн түншлэлийн харилцааны бүрэлдэн бий бололт, хамтын ажиллагааны үйл явцыг судлах болно. Түншлэлийн харилцааны үе шатыг талуудын хооронд байгуулсан хамтарсан тунхаглалд тусгагдсан түншлэлийн харилцаагаар бий болгосон болно. Эдгээр нь харилцан нөхсөн хамтын ажиллагааны харилцаа (1999-2005 он), сайн хөршийн, найрамдал хамтын ажилагааны түншлэл (2006-2011 он), иж бүрэн түншлэлийн харилцаа (2011 оноос өнөөг хүртэл) гэсэн үе шатаар хөгжиж ирсэн.

## II. МОНГОЛ, ӨМНӨД СОЛОНГОСЫН ХАРИЛЦАА ТОГТООХ ҮЙЛ ЯВЦ

### 1. *Дипломат харилцаа тогтоох оролдлого хийж байсан үе*

1990-ээд оны эхээр Монгол Улс дотоод дахь улс төр, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтэй холбоотойгоор гадаад харилцааг үзэл сурталаас ангижирсан бодлогод нийцүүлэх үүднээс өндөр хөгжилтэй улс орнуудтай харилцаа холбоо тогтоох замыг эрэлхийлж эхэлсэн. Нөгөө талаар Орос Хятадын харилцаа сайжирч аюулгүй байдлын гадаад таатай орчин бүрэлсэн нь гадаад бодлогод чухал нөлөө үзүүлж байв. Мөн Зүүн Европын улс орнууд Өмнөд Солонгостой харилцаа тогтоож эхэлсэн нь Монгол Улсыг Өмнөд Солонгостой харилцаа тогтоох урам зоригийг нэмэгдүүлж эхэлсэн юм. Тухайн үед Монгол Улсын хувьд хоёр хөршөөсөө түрүүлж Өмнөд Солонгостой харилцаа тогтооно гэдэг нь амаргүй ажил байсан нь мэдээж хэрэг билээ. Шинэ түнштэй харилцаагаа хөгжүүлснээр үзэл сурталын үед сайн харилцаатай байсан түншүүдтэй харилцаагаа хэрхэн хадгалах вэ гэдэг уян хатан бодлого шаардагдаж эхэлсэн. Нөгөө талаас Өмнөд Солонгосын тал Монгол Улстай харилцах талаар янз бүрийн шугамаар оролдож байсан нь энэ санал өмнөд Солонгосын дэмжлэгийг авах бүрэн боломцоотой гэх дүгнэлтэд хүргэсэн.

Газар нутгийн хувьд Өмнөд Солонгостой ойр дөт ч гэсэн бие биеэ хүлээн зөвшөөрч шинэ түнштэй болно гэдэг бол Монгол Улсын хувьд шинэ бодлогоо хэрэгжүүлэх томоохон шалгуурын нэг байсан. Өмнөд Солонгостой дипломат харилцаа тогтоохын тулд нууц хэлэлцээнүүдийг Токио дахь Монголын элчин сайдаар дамжуулан хийж эхэлжээ. Анхны нууц хэлэлцээ 1990 оны 3 дугаар сарын 16-нд болж хоёр орны Элчин сайд нар хэрхэн яаж дипломат харилцаа тогтоох тухай ярилцаж асуудлыг наантай шийдэгдэх хүртэл талууд чимээгүй байхаар тохиролцжээ[1]. Өмнөд Солонгосын тал Монголын талын саналд наантай хандаж асуудлыг эцэслэн шийдэх зорилгоор 3 сарын 24-28 хооронд ГЯЯ-ны парламентын асуудал хариуцсан орлогч дарга И Ги Чу тэргүүтэй төлөөлөгчдийг илгээснээр хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоогдсон. Мэдээж дипломат

[1]Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны Төв Архив, Х №112 Д№01 ХН№01

харилцаа тогтооно гэдэг бол амаргүй зүйл. Ялангуяа хуучин түншээс энэ асуудалд үзэл сурталын үүндээс хандах болохоор Умард Солонгосын талд харилцаа тогтоох болсон шалтгаанаа тайлбарлан ойлгуулах ихээхэн хэцүү байсан. Монголын Улс Умард Солонгосын хооронд болсон уулзалтын тэмдэглэлүүдээс харахад Умард Солонгосын тал Монгол Улс БНСУ-тай дипломат харилцаа тогтоож буйд харамсаж байгаагаа илэрхийлээд зогсохгүй харилцаа тогтоолгохгүй байх талаар Өмнөд Солонгостой харилцаа тогтоосноор гарах бүх хариуцлагыг Монголын тал хариуцах, дайсаны талтай хөл нийлүүлж нэгдлийн эсрэг зогслоо гэх мэт сүржин мэдэгдэлүүд гаргаж байв[2]. Гэвч Монголын тал ямар учраас өмнөдтэй дипломат харилцаа тогтоох болсон талаарх өөрийн байр сууриа умардуудад тайлбарлан умард, өмнөдтэй аль алинтай нь харилцаагаа адил хөгжүүлэх сонирхолтой байгаагаа уулзалтынхаа үеэр мэдэгдэж байлаа. Нөгөө талаар Монгол Улс 1990 оны 3 дугаар сарын 26-нд Өмнөд Солонгостой дипломат харилцаа тогтоосноо зарласан явдал нь бие даасан гадаад бодлого явуулж эхэлсний баталгаа болсон.

*2. Дипломат харилцаа тогтоох болсон шалгаан*

Тухайн үеийн нөхцөл байдлаас харахад хоёр орны хооронд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх Монголын сонирхол нь үндэсний ашиг сонирхолд нийцсэн бие даасан гадаад бодлогоо хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах гэсэн хоёр үндсэн өдөөгчөөр жолоодогдож байсан. Монгол Улс БНСУ-тай хамтын ажиллагаагаа эхлүүлэхэд эдийн засгийн хамтын ажиллагаа нь гол хөдөлгөгч хүч болсон. Учир нь бусад барууны өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад Монгол, Өмнөд Солонгос нь газарзүйн хувьд бие биетэйгээ ойр юм. Эдийн засгийн хамтын ажиллагааны таатай орчинг бүрдүүлэгч газарзүйн давуу тал нь хоёр орны хооронд эзийн засгийн хамтын ажиллагааны хурдыг хурдасгах нэг холбогч болсон.

Нөгөө талаар шилжилтийн эхэн үед Монголын эдийн засаг ихээхэн уналтад орсон. Зөвлөлтийн ноёрхолын үед Монголын эдийн засаг ЗХУ-аас хамааралтай байсан бөгөөд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний 40 хувь, хүнсний бүтээгдэхүүний 80 хувийг ЗХУ-аас авч байжээ. ЗХУ задран унасаны улмаас Монголын эдийн засаг хүчтэй уналтад орсон. Тиймээс Монголын засгийн газрын нэн тэргүүний зорилт нь нүүрлэсэн эдийн засгийн уналтыг зогсоох, үндэсний эдийн засгийн өсөлтийг хангах идэвхтэй гадаад бодлогыг хайж эхэлсэн. Монгол Улс эдийн засгийн хөгжлийг дэмжих хүрээнд Азийн дөрвөн барын нэг БНСУ-ыг худалдааны том түнш, гол хөрөнгө оруулагч, эдийн засгийн шинэчлэлийн загвар болно хэмээн итгэж байсан.

Нөгөө талаар үндэсний ашиг сонирхолд нийцсэн гадаад бодлого нь улс орны хөгжилд бодит хувь нэмэр оруулахыг харж чадсан. Ингэснээрээ дэлхийн бусад өндөр хөгжилтэй орнуудтай харилцаагаа хөгжүүлэх бодлого гадаад бодлогод томоохон орон зайг эзлэх болсон. Энэ нь тэдгээр улс орнуудтай харилцаа тогтоох, сэргээхэд нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл ардчилал, эдийн засаг өндөр хөгжсөн эдгээр улстай харилцаагаа хөгжүүлэх нь хоёр том гүрнээр хүрээлэгдсэн манайх шиг жижиг улсад тэнцвэртэй харилцааг хадгалахад ихээхэн ач холбодолтой юм. Энэ бодлогоос үүдэн бий болсон гурав дахь хөрш хэмээх нэр томьёо өдгөөгийн Гадаад Бодлогын Үзэл Баримтлалд албан ёсны заалт болон хэлбэршжээ.

## III. ХАРИЛЦАН НӨХСӨН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦААНЫ БАЙГУУЛАЛТ (1999-2006 ОН)

*1. Харилцан нөхсөн хамтын ажиллагааны харилцааны байгуулалт (1999-2006 он)*

1998 онд Ерөнхийлөгч Ким Дэ Жүн засгийн эрхэнд гарч Умард руу чиглэсэн Нарны илч бодлогоос гадна байгалийн нөөц баялагт тулгуурласан гадаад бодлогод сонирхлоо хандуулснаар байгалийн нөөц баялаг ихтэй улс орнуудтай харилцаагаа бэхжүүлэх явдал нэмэгдсэн. 1999 оны 5 дугаар сард Ерөнхийлөгч Ким Дэ Жүн Монгол Улсад төрийн айлчлал хийсэн нь Өмнөд Солонгосын төрийн тэргүүний зүгээс Монгол Улсад хийсэн анхны айлчлал болсон. Энэ үед Солонгосчууд байгалийн нөөц баялагийн талаарх гадаад бодлогоо явуулахдаа Монголыг гол цөмөө болгон анхаарлаа хандуулж байв. Тухайн үед Солонгосын хойгийн асуудалд Монголын

[2] Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны Төв Архив, Х №112 Д№01 ХН№01

хамтын ажиллагаа чухал байсан тул Өмнөд Солонгосын зүгээс идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх сонирхолтой байсан нь энэ айлчлалаас харагддаг.

Ерөнхийлөгч Ким Дэ Жүн, Ерөнхийлөгч Нацагийн Багабанди нар "21 зуунд харилцан нөхсөн хамтын ажиллагааны харилцааг байгуулах "Хамтарсан тунхаглал"-ыг баталсан[3]. Уулзалтын үеэр хоёр орны Ерөнхийлөгчид ЗХА-ийн энх тайван болон хоёр талын хамтын ажиллагааны талаар санал бодлоо солилцсон нь хамтын ажиллагааг хоёр тал, бүс нутгийн хэмжээнд хөгжүүлэх сонирхол байгааг харуулав. Уулзалтаараа Солонгосын хойгт энх тайван, аюулгүй байдлыг бий болгохын төлөөх Солонгосын Засгийн Газрын хүч чармайлтыг Монгол Улс дэмжиж байгаагаа илэрхийлснээс тодорхой харагдаж байна. Ерөнхийлөгч Багабанди нь дээд хэмжээний уулзалтаар "Солонгосын засгийн газраас хэрэгжүүлж буй Умард Солонгосын нарны илч бодлогыг Монгол Улс нь дэмжиж байна[4] хэмээн илэрхийлсэн. Мөн талуудын тэргүүнүүд хамтарсан мэдэгдэлдээ Умард Солонгосын цөмийн зэвсгийг хориглох үүрэг бүхий 1994 оны 10 сарын Женевийн тохиролцоог тууштай хэрэгжүүлэх нь бүс нутгийн аюулгүй байдал төдийгүй цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх олон улсын хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтад чухал хувь нэмэр болно хэмээн үзэв.

Харилцааны энэ үед Солонгосын хөгжлийн туршлага ноухауг Монголын арвин их байгалийн нөөц баялагтай хослуулан харилцан ашигтай хөгжих харилцааг хөгжүүлэхээр тохиролцсон юм. Тухайн үед Монгол Улсад түүний гуравдагч хөршүүдийн нэг хэмээгдэж байсан Солонгосын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа нь зайлшгүй зүйл байсан.

Энэ айлчлалын дараагаар хоёр орны удирдагуудын харилцан айлчлал нэлээд нэмэгдсэн. 1999 оны 10 дугаар сард УИХ-ын Дарга Гончигдорж, 1999 оны 10 дугаар сард Ерөнхий Сайд Р.Амаржаргал нар Солонгост айлчлал хийсэн. 1999 онд Монгол, Солонгосын засгийн газар эрчим хүч, эрдэс баялагийн хамтын ажиллагааны хамтарсан комиссын байгуулсан бөгөөд энэ нь жил бүр ээлжит уулзалтаа хийж байгаа. 2001 онд талуудын хооронд соёлын хамтын ажиллагааны хамтарсан комиссыг байгуулсан бөгөөд хоёр талын соёл, боловсролын яамдууд хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулан харилцаагаа нэмэгдүүлж байна. 2001 оны 2 дугаар сард Ерөнхийлөгч Багабандийн Солонгост хийсэн айлчлал нь хоёр орны хооронд эдийн засгийн харилцааг өргөжин тэлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчин бүрдсэн[5] нь эдийн засгийн харилцааг нэмэгдүүлэх суурь болсон. Мөн Монгол Улс хөгжлийн түншлэлийн хэмжээнд хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд тэргүүлэх салбар болох уул уурхай, дэд бүтэц, аялал жуучлал, ХАА, мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах сонирхолтой байсан нь эдийн засгийн харилцаа өргөжин тэлэхэд нөлөөлсөн. Мөн олон улсын тавцанд ч хамтын ажиллагааг илүү ойртуулан хөгжүүлэхээр болов.

2005 оны 3 дугаар сарын 27-30-ны өдөр Солонгос, Монголын хооронд дипломат харилцаа тогтоосны 15 жилий ойн баярын үйл ажиллагаан дээр Солонгосын Гадаад Хэргийн Сайд Пан Ги Мүн, Монголын Гадаад Харилцааны Яамны Сайд Ц.Мөнх-Оргил нар хоёр орны хөгжил цэцэглэлтийг тохиролцож, 1999 оны 5 дугаар сард төрийн тэргүүнүүдийн хамтран тунхагласан "21 зуунд чиглэсэн харилцан нөхсөн хамтын ажиллагааны харилцаа"-г дахин нотлосон.

[3] 외교통상부."김대중대통령몽골국빈방문(1999.5.30.-6.1.울란바타르)"(1999.06) ; 『연합뉴스』 (1999.5.31).
[4] Монгол Улсын Гадаад Харилцааны Яам. Гадаад Харилцаа мэдээллийн товхимол, 1996 оны 6 сар №13 (63). х-5-7
[5] Монгол Улсын Засгийн Газар. Төрийн мэдээлэл. №34. Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэлийн жагсаалт батлах тухай Засгийн Газрын тогтоол №140

*Хүснэгт 1.*

| Монгол-Өмнөд Солонгос, Монгол-Хойд Солонгосын дээд хэмжээний төлөөлөгчдийн харилцан айлчлал | | | |
|---|---|---|---|
| **Монгол** | **Өмнөд Солонгос** | **Монгол** | **Хойд Солонгос** |
| 1999.5.<br>Ерөнхийлөгч Ким Дэ Жүн (төрийн айлчлал)<br>1999.7.<br>Парламентын Дарга Пак Жүн Гюү | 1991.10. Ерөнхийлөгч П.Очирбат (албан ёсны)<br>1999.10. Их Хурлын Дарга Р.Гончигдорж<br>1999.10. Ерөнхий Сайд Р.Амаржаргал | 1997.3. Гадаад Харилцааны Яамны дэд Сайд Чвэй Ү Жин<br>1998.4. Гадаад Харилцааны Яамны дэд Сайд Чон Жэ Хун<br>1998.10. Гадаадтай соёлоор харилцах хорооны орлогч дарга Мүн Жэ Чол<br>1998.11. Гадаад Хэргийн Яамны дэд сайд Пак Дун Чүн<br>1998.11. Гадаад Хэргийн Яамны Гэрээ Эрх зүйн Дарга И Сон Хён | 1997.12. ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга О.Очиржав<br>1998.1.Гадаад Хэргийн Сайд Ш.Алтангэрэл<br>1998.11. Сангийн Сайд Б.Батбаяр<br>1999.2. Ардчилсан намын дарга Ц.Элбэгдорж<br>1999.9. ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга О.Очиржав<br>1999.11. Ерөнхий Сайд Р.Амаржаргал |
| 2001.6.<br>Ерөнхий Сайд И Хан Дун<br>2003.9.<br>Парламентын Дарга Пак Гван Юун<br>2005.9.<br>Сөүл хотын Дарга И Мён Бак<br>2006.5.<br>Ерөнхийлөгч Ну Мү Хён (төрийн)<br>2007.7.<br>Парламентын Дарга Им Чэ Жон<br>2008.7. Үндсэн Хуулийн Цэцийн Дарга И Ган Гүк<br>2008.9.<br>Гадаад Хэргийн Сайд Юү Мён Хван | 2000.03 Их Хурлын Дарга Р.Гончигдорж<br>2001. 2 Ерөнхийлөгч Н.Багабанди (албан ёсны)<br>2001.08 Их Хурлын Дарга Энэбиш<br>2001.05 Гадаад Хэргийн Сайд Л.Эрдэнэчулуун<br>2003.11 Ерөнхий Сайд Н.Энхбаяр<br>2005. 3 Гадаад Харилцааны Сайд Ц.Мөнх-Оргил<br>2006. 2 Их Хурлын Дарга Ц.Нямдорж<br>2007. 5 Ерөнхийлөгч Н.Энхбаяр<br>2008. 2 Ерөнхийлөгч Н.Энхбаяр (Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолд)<br>2008.10 Ерөнхий Сайд С.Баяр<br>2009.04 Гадаад Харилцааны Сайд С.Батболд<br>2009.12 Гадаад Харилцааны Сайд Г.Занданшатар | 2002.8. Гадаад Хэргийн Сайд Пэг Нам Сүн<br>2007. Ардын Дээд Хурлын Тэргүүлэгчдийн Дарга Ким Ён Нам | 2003. Ерөнхий Сайд Н.Энхбаяр<br>2004. Ерөнхийлөгч Н.Багабанди |
| 2011.11<br>Ерөнхийлөгч И Мён Бак (төрийн) | 2010.2. Их Хурлын Дарга С.Дэмбэрэл<br>2011.3. Ерөнхий Сайд С.Батболд<br>2012.5. Гадаад Харилцааны Сайд Г.Занданшатар<br>2012.11. Гадаад Харилцааны Сайд Л.Болд (албан бус) | 2011.7. Гадаад Хэргийн Сайд Пак Ы Чүн | 2010. Гадаад Харилцааны Сайд Г.Занданшатар |

Эх сурвалж: 외교부동북아 3 과, 『몽골개황』(2011. 08), p. 78 과 p.118 에서수정보완함.

### 2. *Умард Солонгосыг харгалзан үзсэн Монголын бодлого*

Солонгос, Монголын харилцааны хөгжилд Умард Солонгос нь таагүй ханддаг байсан нь 1998 оны 5 дугаар сард Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Ким Дэ Жүний Монгол Улсад хийсэн төрийн айлчлалаас гарсан үр дүнгээс харагддаг. Өөрөөр хэлбэл хоёр талын дээд хэмээний уулзалтаар Ерөнхийлөгч Н.Багабанди Ерөнхийлөгч Ким Дэ Жүний нарны илч бодлогыг дэмжсэн явдлыг Умард Солонгосын зүгээс хүндээр тусган авсан. 8 дугаар сард Умард Солонгосын Засгийн Газар эдийн засгийн хүндрэл бэрхшээлийн улмаас Монгол дахь Элчин Сайдын Яамаа хааж хоёр орны харилцаанд хүйтэн уур амьсгал бий болсон. Умард Солонгос Элчин Сайдын Яамаа хаасан явдал нь улс төрийн талаасаа Нарны илч бодлогыг эсэргүүцсэн нөгөө талаар Ким Ил Соноос хойш бий болсон эдийн засгийн хямрал хэмээх хоёр хүчин зүйлээр тайлбарлаж болох юм. Ким Ил Сон нас барсаны дараа Умард Солонгос нь эдийн засгийн хямралыг нүүрлэсэн. Тухайн үед Умард Солонгост өлсгөлөн гарч олноороо дүрвэн гарах явдал бий болж улс орон хямралыг биеэрээ амссан. Монгол болон Умард Солонгосын худалдааны хэмжээ 1998 онд 84.3 мянган ам доллар[6] болж өмнөх оноосоо буурч эдийн засгийн харилцаа өчүүхэн хэмжээнд хүрсэн.

Ийнхүү Умард Солонгосын зүгээс Монголоос зай барьсан стратегийг баримтлах болсон учир Монгол Улсын Засгийн Газар нь Умард Солонгосын Засгийн газарт адил, тэгш, тэнцвэртэй харилцааг хөгжүүлнэ хэмээн Умардыханыг ятган Умард Солонгосыг харгалзан үзсэн гадаад бодлогыг явуулж байсан. 2002 оны 8 дугаар сард Гадаад Хэргийн Сайд Пэг Нам Сүн Монголд айлчилж Найрсаг Харилцаа, Хамтын ажиллагааны шинэ Гэрээнд гарын үсэг зурсанаар харилцаа цэцэглэж эхэлсэн. 2003 оны 11 дүгээр сард Ерөнхий Сайд Н.Энхбаяр Умард Солонгост айлчилж хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, хамгаалах тухай хэлэлцээрийг байгуулж, Монголд Умард Солонгосын элчин сайдын яамыг дахин нээх зэрэг асуудлаар тохиролцсон. 2004 онд Ерөнхийлөгч Н.Багабанди Умард Солонгост айлчлах үеэр "Худалдааны тухай Монгол Улсын Засгийн Газар, БНАСАУ-ын Засгийн Газар хоорондын хэлэлцээр"-ийг байгуулсан[7]. Мөн хоёр тал нь дүрвэгсэдийн хуаран байгуулахгүй байх асуудлаар тохиролцож, уламжлалт найрамдал хамтын ажиллагааны харилцаагаа сэргээсэн.

2005 оны 2 дугаар сард Умард Солонгосын Дэдун Кредит Банкнаас Голомт Банканд шилжүүлсэн 10 сая ам долларыг Монгол Улсын Засгийн Газар хуурамч байж болзошгүй хэмээн хураан авч шалгаснаар хоёр орны харилцаанд таагүй уур амьсгал бий болсон. Монгол Улс нь барилга-уул уурхайн салбарт Хятад ажилчид хэт ихэссэн асуудлыг шийдэхийн тулд Умард Солонгосоос мэргэшсэн ажилтан авах сонирхолтой байдаг. 2007 оны 7 дугаар сард Ардын Дээд Хурлын Тэргүүлэгчдийн Дарга Ким Ён Намыг Монголд айлчлал хийх үед "Ажиллах хүч харилцан солилцох тухай хэлэлцээр"-ийг байгуулсан бөгөөд Монголын аж ахуйн нэгжүүд гадаад ажилчин авч ажиллуулсны төлөө ажлын байрны төлбөр төлдөг бол Умард Солонгосын ажилчдын хувьд энэ төлбөрөөс чөлөөлөгдсөн. Монгол Улсын Засгийн Газраас өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлаас ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын Засгийн Газар, БНАСАУ-ын Засгийн Газар хоорондын хэлэлцээрийг 2007 оны 7 дугаар сард соёрхон баталсан бөгөөд энэ хэлэлцээр ёсоор Умард Солонгосын 5.000 ажилтанг авч ажиллуулах зорилготой байгаа юм[8].

Монгол Улс нь Солонгосын хойгийн түгшүүртэй байдлыг намжаахын тулд 6 Талт Хэлэлцээний оролцогч улс биш ч гэсэн Умард Солонгосыг ганцаардуулахгүй, нээлттэй болгоход чиглүүлэх зорилгоор 6 Талт Хэлэлцээний "ЗХА-ийн энх тайван, аюулгүй байдлын системийн ажлын хэсгийн уулзалт"-ыг зохион байгуулах хүч чармайлт тавьж ирсэн. Энэ хичээл зүтгэлийн үр дүнд 2007 оны

[6] Гадаад Харилцааны Төв Архив СХ №3, Д№1. ХН №209

[7] 잔즈브도르권롬보, 몽골, 조선민주주의인민공화국관계 60 년 (60 years of Relations Between Mongolia and The Democratic People's Republic of Korea). 2007, 평양, p-125-128.

[8] 2013 оны 4 дүгээр сарын байдлаар Монгол Улсын Хөдөлмөрийн Яам гадаадын нийт ажилчдын тоог гаргасан бөгөөд 103 улсын 12064 гадаад ажилчин байгаа юм. Түүнээс нэгт Хятадын 58976 ажилчин (50%), хоёрт Хойд Солонгосын ажилчин 1749 (15%), Оросын 528 ажилчин, Америкийн 428 ажилчин, Вьетнамын 414 ажилчин байна. "몽골노동부의외국인노동자현황" ( http://www.rfa.org/korean/in_focus/ne-jw-07022013164635.html, 검색일: 2013 년 9 월 25 일).

9 сар болон 2012 оны 3 дугаар сар, 12 дугаар сард Умард Солонгос, Японы нууц уулзалтыг Улаанбаатарт зохион байгуулсан.

### 3. *Соёлын харилцааны тэлэлт ба халлюгийн салхилалт*

Сүүлийн жилүүдэд Монгол Улс нь соёл-сэтгэхүйн хувьд адил төстэй Солонгосын соёлыг сонирхох байдал нь нэмэгдэж 1998 онд Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизээр "Элсэн цаг" Солонгосын олон ангит кино гарсан нь анхны Солонгос олон ангит кино болсон. Үүнээс хойш Монголд Халлюгийн давалгаа түрэн орж ирсэн. Зөвхөн олон ангит кино ч биш Солонгосын загвар, гоо сайхны бүтээгдэхүүн зэрэг нь моод болон дэлгэрч халлю нь Монголчуудын өдөр тутмын амьдралын нэг хэсэг нь болсон. Мөн түүнчлэн Солонгос хоолны нэгүүд үүх явдал газар авч Улаанбаатарт Солонгос хоолны газрууд олон болсон.

Солонгост Монгол оюутан, ажилчид хурдтай нэмэгдсэн. 2000-аад онд Монголын гадаад хүмүүстэй гэрлэсэн хүмүүсийн хувийг харвал Солонгос хүнтэй гэрлэсэн хүний тоо хамгийн их байна. Энэ үед Монголд ойролцоогоор 2,000 Солонгосчууд оршин сууж байсан бөгөөд Солонгост ойролцоогоор 20,000 орчим Монголчууд амьдарч байсан. Солонгосын Гадаад Харилцааны Яамнаас 2 жилд 1 удаа гаргадаг гадаадад оршин суугаа эх орон нэгтнүүдийн тухай судалгааны материалын дагуу 2005 онд 1,497, 2007 онд 2,501, 2009 онд 2325, 2011 онд 2,238 хүн амьдарч байна. Энэ статистик нь Монгол Солонгосын нийгэмлэг зэрэг газрын гаргасан статистик тоо бөгөөд Гадаад Харилцааны Яам нь 3,000 орчим хүн байгаа гэж тооцоолж байна.

2000 оноос хойш Солонгост байгаа Монголчуудын амьдралыг ая тухтай байлгах асуудал урган гарч ирсэн бөгөөд жил ирэх тусам тэдний амьдралыг ая тухтай болгох зүйлс нэмэгдэж байна. Түндэмүний Монгол таун, Шингилдүн, Жанханпён, Кёнгидү, Бэжонбу, Ансан, Сувон зэрэг газруудад Монголчууд амьдарч Монгол хоол, тээврийн компани, аялал жуулчлалын газар, олон улсын утасны компани, валют солих газар зэрэг тэднийг ая тухтай байлгах зүйлс нэмэгдэж байна. 1998 оны 10 дугаар сард Намянжү болон Улаанбаатар хотын хооронд харилцах хэлэлцээрийг байгуулан Намянжү хотын Сүдуимёна Монголын соёлын төвийг байгуулсан. Монголын соёлын төвд Монгол соёл, түүх, экологи зэрэг сургалчилгааны үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд Монгол ардын дуу бүжиг, урлаг, урлагийн тоглолт, морьтон залуусын үзүүлбэр зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Мөн түүнчлэн 2001 онд Улаанбаатарт Намянжүгийн соёлын төв байгуулагдсан. 2001 онд Улаанбаатар Сөүл хотын дэмжлэгээр Сөүлд "Улаанбаатарын соёлыг дэмжих төвийг байгуулан Солонгост Монгол соёлын талаарх сурталчилгаа, монгол хүний хөгжил мөн хоёр талын найрамдалт харилцааг хөгжүүлэх талаар хүчин чармайлт гаргаж байна". 2009 онд Солонгосын Гадаад хэлний их сургуульд Монгол судлалын тэнхим нээгдсэн.

Харилцаа тогтоосноос хойш 2007 он хүртэл Монгол Солонгосын худалдааны хэмжээ хурдтайгаар өсөн нэмэгдэж байсан. Гэвч 2008 онд Америкаас эхэлсэн санхүүгийн хямралаар Солонгос, Монголын эдийн засаг нь түр зуурын зогсонги байдалд орж эдийн засгийн харилцаа багассан. Үүний дараагаар эрдэс баялгийн экспортын үндсэн болгосон Монголын эдийн засаг нь жилд 8-10 хувийн өсөлттэй байсан бөгөөд хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаа шууд сайжирч эхэлсэн.

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

## IV. ИРЭЭДҮЙД ЧИГЛЭСЭН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦААНЫ ХЭЛБЭР

### *1. Сайн хөршийн найрамдалт хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа*

2006 оны 5 дугаар сарын 8-нд Ерөнхийлөгч Ну Мү Хён нь Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Монголд төрийн айлчлал хийсэн. 5 дугаар сарын 8-нд хоёр талын Ерөнхийлөгч нар дээд хэмжээний уулзалтыг хийж хоёр талын эдийн засаг-нийгэм-соёлын салбар төдийгүй улс төр-аюулгүй байдлын салбар зэрэг бүх салбарт найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар харилцан ашиг сонирхлоо илэрхийлсэн "Сайн хөршийн найрамдалт хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа"-г хөгжүүлэхээр тохиролцсон[13]. Талууд эдийн засаг-худалдааны салбарт харилцаа, хамтын ажиллагаа чухал байгаа талаар санал нэг байсан[14].

Хэвлэлийн бага хурлын үеэр Ерөнхийлөгч Ну Мү Хён нь "Сайн хөршийн найрамдалт хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа"-г хөгжүүлэхийн тулд хоёр орны хооронд бүх салбарт дээд хэмжээний төлөөлөгчдийг харилцан солилцох явдлыг тэлэх нь мэдээж хоёр орны Гадаад Харилцааны Яамд хоорондын яриа хэлэлцээний тогтолцооноос ч илүү чухал зүйл болох юм. Үүний зэрэгцээ Монголын мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэхэд мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхийн тулд энэ салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхээр онцлон тэмдэглэсэн. Ерөнхийлөгч Ну Мү Хён нь мөн энэ айлчлалын үеэрээ Нийгмийн хамгааллын талаарх хэлэлцээр, ашигт малтмалын хамтарсан судалгаа-хөгжлийн хамтын ажиллагааны харилцан ойлголцолын санамж бичиг зэрэг нийт 18 баримт бичигт гарын үсэг зурж цаашид гадаад харилцааны төдийгүй цэргийн тангуулын талаар хамтын ажиллагаагаа хөгжүүлэхээр болсон[15].

2007 оны 7 дугаар сарын 28-нд Ерөнхийлөгч Н.Энхбаяр Солонгост хариу айлчлал хийн Ерөнхийлөгч Ну Мү Хёнтой дээд хэмжээний уулзалт хийсэн бөгөөд талуудын хооронд "Сайн хөршийн найрамдалт хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа"-г өргөжүүлэн гүнзгийрүүлэхийн тулд дээд хэмжээний төлөөлөгчид солилцон эдийн засаг-худалдаа зэрэг бодит салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэхээр тохиролцсон.

### *2. Хоёр талын өнөөгийн харилцааны хэлбэр*

2010 онд Солонгос, Монголын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойг тэмдэглэн Монгол дахь Солонгосын жил, 2011 онд Солонгос дахь Монголын жил хэмээн тогтоож олон янзын арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. 2012 онд Улаанбаатарт ойролцоогоор 90 орчим Солонгос хоолны газар үйл ажиллагаагаа явуулж байсан (эдгээрийн дотор Монголчуудын өөрийнх нь байгуулсан 20 хоолны газар байна.) бөгөөд үйлчлүүлэгчдийн 80 гаруй хувь нь Монголчууд байдаг нь солонгос хоол нэлээд эрэлт ихтэй байдаг нь харагдаж байна.

2012 онд 26 их, дээд сургуульд Солонгос хэл зааж байгаа бөгөөд Солонгос судлалыг шинээр бий болгож, ойролцоогоор 4 мянга орчим оюутан сурч байна[16]. Солонгос оюутаны тоо ч гэсэн хурдтай өсөн нэмэгдэж ойролцоогоор 5 мянга орчим оюутан байна. Солонгос хэлийг сурах явдал бага, дунд сургуулиудад ч гэсэн өргөжиж байна. Мөн жирийн иргэдэд Солонгос хэлний боловсрол олгох курс, дамжаанууд байдаг.

[13] 외교통상부, "한·몽공동성명(노무현대통령과엥흐바야르대통령)"(몽골방문), 2006.05.09.).

[14] Хоёр улсын төрийн тэргүүнүүд нь нэгдүгээр, Монголын байгалийн баялагийг Солонгосын техник-хөрөнгөтэй хослуулан эрдэс баялаг-эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа, хоёрдугаарт, дэд бүтцийн тоног төхөөрөмжийг хөгжүүлэхэд тусламж дэмжлэг үзүүлэхийн тулд барилга байгууламжийн талаарх хамтын ажиллагаа, гуравдугаарт, Монголын өргөн уудам газар нутаг, Солонгосын техникийг хослуулан ХАА-н хамтын ажиллагаа зэрэг ирээдүйд чиглэсэн салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхээр тохиролцсон.

[15] "한・몽골 '선린우호협력동반자관계' 구축", 「연합뉴스」 (2006. 5. 8).

[16] Монголын гол их, дээд сургуулиудад Солонгос судлалын тэнхимүүд байгуулагдсан нь дараах байдалтай байна. Үүнд: 1991онд МУИС, 1992 онд Гадаад хэлний дээд сургуульд (ХУИС), 1993 онд Улаанбаатар дээд сургууль, 1998 онд Орхон Их Сургууль, 2000 онд Боловсролын Их Сургууль, 2001 онд Солонгос, Монголын технилогийн дээд сургууль, 2002 онд ШУТИС. Улсын 6 их сургууль, хувийн 15 дээд сургуульд солонгос судлалын тэнхим байна. 2011 онд бага, дунд сургуульд солонгос хэлний хичээл орж байгаа бөгөөд нийт 11 сургуульд 1487 хүүхэд сурч байна.

*Хүснэгт 2*

| *Хоёр орны ард иргэд харилцан айлчилсан байдал* | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| *Он* | **2002** | **2003** | **2004** | **2005** | **2006** | **2007** | **2008** | **2009** |
| *Солонгосчууд Монголд* | 13,347 | 16,861 | 25,918 | 31,227 | 32,246 | 38,959 | 43,751 | 39,766 |
| *Монголчууд Солонгост* | 8,840 | 12,111 | 17,290 | 22,626 | 32,580 | 39,860 | 43,113 | 38,192 |

Эх сурвалж: 몽골공항출입국관리소: 외교부동북아 3 과, 『몽골개황』 (2011. 08).

2012 оны хувьд Солонгост 61,766 хүн, Монголд 44,360 хүн айлчилсан. Солонгост 26,461 Монгол хүн амьдардаг бөгөөд энэ нь Монголын хүн амыг ойролцоогоор нэг хувь нь болж байна. Эдгээрээс 32,8 хувь нь хууль бусаар оршин сууж байгаа хүн байна.

Солонгост ажиллаж амьдарч байгаа хүмүүс жилд ойролцоогоор 300 сая ам долларыг Монгол руу гуйвуулдаг гэсэн тооцоо гаргасан. Монголын Засгийн Газар Монголчууд Солонгост ажиллан техник технологийг нь сурч эх орныхоо эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахыг хүсч байдаг. Солонгост байгаа ажил нь ихэнхдээ мэргэжил шаардлагагүй, технологи муу хөгжсөн салбарт байдаг бөгөөд бодит байдал нь Монголын талын найдаж байгаа байдлаас өөр юм[17].

*Хүснэгт 3*

| *Монгол оюутнуудын Солонгост суралцсан байдал* | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ***Жил*** | ***2003*** | ***2004*** | ***2005*** | ***2006*** | ***2007*** | ***2008*** | ***2009*** | ***2010*** |
| ***Оюутаны тоо*** | 208 | 365 | 510 | 809 | 1309 | 2022 | 2724 | 3333 |

Эх сурвалж: 외교부, 『몽골개황』 (2011, 11, 8). 통계기준: 2010 년 4 월.

2010 онд Солонгосын Засгийн Газрын урилгаар ирсэн Монгол оюутаны тоо нь Солонгосын Засгийн Газрын урилгаар ирсэн гадаад оюутаны (тоо нийт 1,942 оюутан) 7.9 хувиар 3 дугаар байрт бичигдсэн. Мөн гадаадын засгийн газрын урилгаар гадаадад сурч байгаа Монгол оюутаны тоо нь 5,560 бөгөөд түүний дотор Солонгост сурч байгаа оюутаны тоо нь 171 буюу 3.1 хувиар Орос (2,034 буюу 36.6 хувь), Хятад (1,240 буюу 22.3 хувь), Турк (616 буюу 11.1 хувь), Япон (594 буюу 10.7 хувь), Энэтхэг (268)-ийн дараагаар 6 дугаар байрт бичигдэж байна. Солонгост суралцаж байгаа Монгол Оюутаны Холбоо үйл ажиллагаагаа явуулж байна[18].

Монгол Улсад Улаанбаатарт төвлөрсөн Солонгосын 3 мянган хүн амьдарч байна. Оршин сууж байгаа хүмүүсийг мэргэжлээр нь ангилбал бизнес болон ажил гэсэн зорилгоор оршин сууж байгаа энгийн иргэд нь 2,124, суралцаж байгаа оюутан нь 114 байна. Бүс нутгаар нь авч үзвэл Улаанбаатарт 2,202 иргэн, Дарханд 32 иргэн, Эрдэнэтэд 4 иргэн байна[19]. Солонгосчуудын гол байгууллагаар Монгол дахь Солонгосчуудын нийгэмлэг, Монгол дахь Солонгосчуудын худалдаа, аж үйлдвэрийн газар зэрэг байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна[20]. Сөүл, Улаанбаатарын хоорондох харилцаа зэрэг орон нутгийн байгууллагуудын хоорондох харилцаа явагдаж байна.

2013 оны 6 дугаар сарын 26-нд Солонгосын худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг нь Улаанбаатарт салбараа байгуулсан. Солонгосоос Монголд хөрөнгө оруулсан нийт хөрөнгийн хэмжээ нь 2012 он хүртэл 2.9 тэрбум ам доллар, буцалтгүй тусламж нь 1.64 тэрбум ам доллар. Хөрөнгө оруулалтаараа Солонгос нь 4 дүгээрт бичигдэж байна. Монголын статистикийн газрын мэдээллээр худалдааны хэмжээ нь 4.92 тэрбум ам доллар. Солонгосын экспорт нь 4.8 тэрбум ам доллар, импорт нь 12 сая ам доллар байна. 1990 онд дипломат харилцаа тогтоож байх үед худалдааны хэмжээ нь 2 сая 710 мянган ам доллар байсантай харьцуулахад эдийн засаг

17 외교부동북아 3 과, 『몽골개황』 (2011 08). 120 쪽.

18 외교부, 『몽골개황』 (2011, 11, 8). 통계기준: 2010 년 4 월

19 외교부동북아 3 과, "몽골약황"(2013, 07).외교부, 『국가별재외동포현황』 (2011), p. 7, p..

20 외교부, 『재외동포단체현황』 (2013).

худалдааны талаасаа ихээхэн хөгжилд хүрсэн байна. Солонгос нь Монголын 5 дахь худалдааны түнш болсон. Гэвч Монголын эдийн засгийн эмзэг нөхцөл байдлаас болоод Монголын худалдааны алдагдал нэмэгдэж байна.

*Солонгос, Монгол хоорондын экспорт импортын байдал (2000-2012) (нэгж: мянган ам доллар)*

*Хүснэгт 4*

| *Жил* | *Экспортын тоо* | *Экспортын мөнгөний хэмжээ* | *Импортын тоо* | *Импортын мөнгөний хэмжээ* | *Худалдааны орлого зарлага* |
|---|---|---|---|---|---|
| **2000** | 3,704 | 54,672 | 151 | 2,077 | 52,596 |
| **2001** | 3,655 | 76,567 | 191 | 2,348 | 74,219 |
| **2002** | 5,079 | 87,228 | 502 | 5,716 | 81,512 |
| **2003** | 5,074 | 99,525 | 432 | 3,923 | 95,602 |
| **2004** | 5,958 | 75,320 | 311 | 4,594 | 70,726 |
| **2005** | 6,515 | 77,621 | 307 | 4,895 | 72,726 |
| **2006** | 8,695 | 110,306 | 409 | 6,440 | 103,865 |
| **2007** | 11,214 | 169,758 | 437 | 20,729 | 149,029 |
| **2008** | 14,766 | 238,231 | 420 | 31,150 | 207,082 |
| **2009** | 8,468 | 166,887 | 993 | 21,479 | 145,409 |
| **2010** | 12,127 | 191,631 | 5,032 | 38,839 | 152,792 |
| **2011** | 20,167 | 349,874 | 11,657 | 60,623 | 289,251 |
| **2012** | 21,797 | 433,457 | 18,047 | 53,598 | 379,858 |

Эх сурвалж: "국가별수출입실적," 관세청 http://www.customs.go.kr ( 검색일: 2013.11.27).

### *3. Иж бүрэн түншлэлийн харилцааны байгуулалт (2011 он)*

2010 онд Монгол Улсын Их Хурал нь Их Хурлаас батлан гаргасан 1994 оны "Гадаад бодлогын үзэл баримтлал", "Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал"-уудыг дахин шинэчилж улсын аюулгүй байдлын үндсэн зарчмыг баталсан. Энэ үндсэн зарчим нь "гуравдагч хөршийн бодлого"-ыг өргөжүүлэн хөгжүүлсэн үзэл баримтлал болсон. 2011 оны 2 дугаар сарын 10-нд Монгол Улсын Засгийн Газар "Гадаад бодлогын үзэл баримтлал, Гадаад бодлогын үндсэн төлөвлөгөө"-г гаргасан. Энэ үзэл баримтлалд Солонгосыг хамтын ажиллагаагаа хөгжүүлэх чухал орнуудын нэг гэж хамруулсан. 2012 оны 9 дүгээр сард Монгол Улсын Засгийн Газар цаашид ажиллах 4 жилийнхээ үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан бөгөөд энэ хөтөлбөртөө Орос, Хятад, гуравдагч орнуудтай стратеги, иж бүрэн түншлэлийн харилцааг бат бөх бэхжүүлэхээр тусгасан. Тиймээс Солонгос, Монголын хоёр талын харилцаа нь 2016 он хүртэл улам нягт ойртон хөгжих явдал харагдаж байна[21].

2011 оны 3 дугаар сард Ерөнхий Сайд Батболд Солонгост айлчилж эдийн засгийн хамтын ажиллагаа болон Монголын ашигт малтмалд оруулсан Солонгосын хөрөнгө оруулалтыг хамгаалах талаар уулзалтаа хийсэн[22].

2011 оны 8 дугаар сарын 22-нд Ерөнхийлөгч И Мён Бак Монгол Улсад төрийн айлчлал хийж, Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржтой дээд хэмжээний уулзалт хийн хоёр орны харилцааг "иж бүрэн түншлэл"-ийн харилцаагаар хөгжүүлэхээр тохиролцон "Монгол, Солонгосын хамтарсан тунхаглал"-ыг баталсан. Монгол, Солонгос нь дипломат харилцаа тогтоосны 20 жилийн дараа иж бүрэн түншлэлийн түвшинд харилцаагаа хөгжүүлэхээр болсон. Хоёр орны төрийн тэргүүнүүд нь хамтарсан тунхаглалдаа цаашдын хамтын ажиллагааны харилцааг бүх салбарт тэлэн хөгжүүлэх, ингэхийн тулд хоёр талын хамтын ажиллагааг нэн тэргүүнд тодорхойлсон "Солонгос-Монголын хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр"-ийг байгуулсан ба энэ нь дунд болон урт хугацааны хамтын ажиллагааг нарийвчлан гаргахад чиглүүлэгч үндэс нь болсон. Эдийн засаг,

[21] Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2012-2016, http://politics.news.mn/content/118798.shtml

[22] 이성규, "한국과몽골의정치, 경제교류의현황과발전방안," 『앞의책』, p.17-18

худалдааны хамтын ажиллагааны гол цэг нь болсон дунд хугацааны хөтөлбөр ёсоор Солонгос нь Монголын дэд бүтэц, барилгын салбарт хөрөнгө оруулалтаа тэлж хамтран ажиллахаар болсон[23]. Солонгостой Монгол нь ашигт малтмал, мэдээллийн технологи, эрчим хүч, хүнд үйлдвэр, барилга, далайн тээвэр, усан боомт, эрүүл мэнд, ХАА-н салбарт харилцан хамтын ажиллагаагаа хөгжүүлэхээр болсон.

Өмнөд, Умардын харилцаатай холбоотой асуудлаар хоёр тал нь 6 Талт хэлэлцээрийг сэргээх нөхцөлийг бий болгох, өмнөд, умардын хооронд үр дүнтэй яриа хэлэлцээг үргэлжлүүлэн хийх явдал нь чухал талаар санал нэгтэй байв. Талууд нь Умард Солонгосын уран баяжуулах хөтөлбөрийн үйл ажиллагаанд санаа зовж байгаагаа илэрхийлээд Умард Солонгос нь эргэлт буцалтгүй, магадлах боломжтойгоор татгалзах нь бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын бэхжүүлэхэд чухал болох талаар санал нэгтэй байгаагаа илэрхийлэв[24]. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нь "Монгол Улсын Засгийн Газар 6 Талт Хэлэлцээрийг ямагт дэмжиж ирсэн бөгөөд цаашид ч гэсэн 6 Талт Хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулж байгаа хурал уулзалт нь бодит үр дүнд хүрнэ' гэж найдаж байгаагаа илэрхийлсэн. 6 Талт Хэлэлцээр нь зогсонги байдалд орсон нөхцөл байдалд байгаа тул талуудын тэргүүнүүдийн хамтарсан мэдэгдэлд 6 Талт Хэлэлцээрийг дэмжсэн утгыг оруулж өгсөн[25].

## V. ДҮГНЭЛТ

1990 оны 3 дугаар сард дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны харилцаа нь олон чиглэлээр хөгжиж байна. Энэ нь түүх, үндэс угсаа, хэл, соёлын адил төстэй байдал болоод улс төр, эдийн засаг, соёлын салбарын харилцан нөхсөн шинжийг үндсээ болгож байна. Хоёр орны харилцааг эргэн харвал ерөнхийд нь болон үндсэн цаг үеэр ангилбал дараах байдалтай байна.

*Нэгдүгээрт,харилцаагаа хэвийн болгосон үе.* 1990 оны 3 дугаар сард Монгол Улсын Засгийн Газар нь Японд байгаа Солонгосын Элчин сайдын яамаараа дамжуулан дипломат харилцаа тогтоох уулзалт хийх талаар анх санал тавьсан. Энэ үед засгийн эрхийг барьж байсан Ну Тэ У нь Умардын бодлогыг явуулж байсан тул хоёр тал нь амжилттайгаар дипломат харилцаа тогтоосон. Дипломат харилцаа тогтоосны дараагаар талуудын харилцаа хурдтай өсөн нэмэгдсэн. Дипломат харилцаа тогтоох үед Монголын талд хоёр орны хооронд харилцаа тогтоох гэж байгаа тухайгаа социалист ах дүү орон болох Умард Солонгост хэлж түүнийг ятгах ажил нь хэцүүхэн асуудал байсан. Дипломат харилцаа тогтоосны дараагаар Монголтой Умард Солонгос нь уламжлалт найрамдалт хамтын ажиллагааны харилцаагаа хадгалж, Монгол нь Умард Солонгосыг бодолцож үзсэн Өмнөд, Умардтай хоёулантай нь сайн байх гадаад бодлогыг явуулж байсан.

*Хоёрдугаарт, түншлэлийн харилцааны үе.* Албан ёсоор түншлэлийн харилцаа нь гурван үе шаттайгаар тунхаглагдсан. 1999 оны 5 дугаар сард Ерөнхийлөгч Ким Дэ Жүн, Ерөнхийлөгч Багабандийн хооронд "21-р зуунд харилцан нөхсөн хамтын ажиллагааны харилцаа", 2006 оны 5 дугаар сард Ерөнхийлөгч Ну Мү Хён, Ерөнхийлөгч Н.Энхбаярын хооронд "Сайн хөршийн найрамдалт хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа", 2011 оны 8 дугаар сард Ерөнхийлөгч И Мён Бак, Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хооронд "Иж бүрэн түншлэлийн харилцаа"-г байгуулсан. Хоёр орны өндөр дээд түвшний улс төрийн харилцаа болон 2000 оны эхний хагаст Монголд Халлю хүчтэй дэлгэрсэн зэрэг нь хоёр орны нийгэм соёлын салбарт төдийгүй улс төрийн холбоог бэхжүүлэхэд хувь нэмэр болсон.

Энэ үед Өмнөд Солонгосын зүгээс Монголын талаар явуулж байсан бодлого нь ашигт малтмал болон солонгосын хойгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтарч ажиллах явдал байсан. Өөрөөр хэлбэл Солонгосын зүгээс Монголыг байгалийн нөөц баялагийн гол түнш орон мөн

[23] 청와대정책브리핑, "한-몽골, 포괄적동반자관계격상: 정상회담갖고공동성명...에너지 자원분야 MOU 도" (2011 년 8 월 22 일), (http://www.korea.kr/policy/diplomacyView.do?newsId=148717034 검색일, 2013. 9. 23).

[24] 청와대정책브리핑( 2011, 8, 22).

[25] 청와대정책브리핑( 2011, 8, 22).

Солонгосын хойг болон ЗХА-д энх тайвны системийг бий болгоход чухал түншүүдийн нэг гэж Монголыг ойлгож байсан. Монгол Улс нь Орос, Хятадын нөлөөг хязгаарлахын тулд Солонгосыг хөрөнгө оруулалт, худалдааны түнш орон, мөн хөгжлийн загвар орон зэргээр үзэж байсан. Солонгос болон Монгол нь ЗХА-ийн буфер улс болохын хувьд харилцан стратегийн үнэт зүйлсээ сайтар ухамсарлан далай, эх газрыг холбосон гүүр улсынхаа үүргийг ашиглах шаардлага байна.

*Хүснэгт 5*

***Солонгос, Монголын гадаад харилцааны байгууллалтын өнөөгийн нөхцөл байдал***

| *Солонгосын гадаад харилцаа* | *Монголын гадаад харилцаа* |
|---|---|
| • Америк: стратегийн холбоотон<br>• Хятад, Орос, Вьетнам: стратегийн хамтын ажиллагааны түншлэл<br>• Энэтхэг, Мексик, Казахстан: стратегийн түншлэл<br>• Франц, Монгол: иж бүрэн түншлэл | • Хятад, Япон, Орос: стратегийн түншлэл<br>• Америк, Энэтхэг, Солонгос: иж бүрэн түншлэл<br>• Австрали: өргөн хүрээтэй түншлэл |
| ***Солонгос, Монголын харилцаа*** | |
| ○ 1990 оны 3 дугаар сар, дипломат харилцаа тогтоосон<br>○ 1999 оны 5 дугаар сар, 21 зуунд харилцан нөхсөн хамтын ажиллагааны харилцаа: Ерөнхийлөгч Ким Дэ Жүн, Ерөнхийлөгч Н.Багабанди<br>✓ Умард Солонгос Монголын харилцаа: 2002 оны 8 дугаар сар, Найрамдалт, хамтын ажиллагааны харилцаа: Гадаад Хэргийн Сайд Пэг Нам Сүн<br>○ 2006 оны 5 дугаар сар, Сайн хөршийн найрамдал хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа: Ерөнхийлөгч Ну Мү Хён, Ерөнхийлөгч Н.Энхбаяр<br>○ 2011 оны 8 дугаар сарын 22. Иж бүрэн түншлэлийн харилцаа: Ерөнхийлөгч И Мён Бак, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж | |
| Эх сурвалж: 외교부동북아 3 과, 『몽골개황』 (2011. 8), p. 118. 에서수정보완함 | |

Цаашид Монгол, Солонгосын харилцаа нь худалдаа, хөрөнгө оруулалт, эрдэс баялагийг хөгжлийн гол хөдөлгөгч хүчээ болгосон үйл ажиллагааг явуулан хамтын хөгжлийн төлөө хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарал хандуулах хэрэгтэй байна. Хоёр орны геополитикийн онцлог байдлыг харилцан нөхөхийн тулд талууд харилцаагаа бэхжүүлж болохуйц олон янзын харилцааны сувгийг тэлэхийн зэрэгцээ цэргийн хүчийг биш өөр арга хэрэгслийг ашиглан аюулгүй байдлын баталгааг олох хэрэгтэй байна. Үүний дотор Солонгост байгаа монголчуудын сүлжээ, Монгол дахь халлюгийн өсөлт зэрэг таатай уур амьсгалыг ашиглан Солонгос болон Монголын хооронд соёл, боловсрол, эдийн засгийн хамтын ажиллагааг үндсээ болгосон гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлд хоёр орны нэгдмэл харилцан хамаарлын хүч чадлыг тэлэх хэрэгтэй байна. Мөн түүнчлэн Солонгос болон Монгол нь "иж бүрэн түншлэлийн харилцаа" хэмээх харилцааг байгуулахад тохирсон олон талын бүтээлч, цогц харилцан бие биенээсээ хамааралтай харилцааг бий болгоход тэмүүлэх хэрэгтэй байна.

## НОМ ЗҮЙ


***Монгол материал***

1. Монгол Улсын Гадаад Харилцааны Яам. Гадаад Харилцаа мэдээллийн товхимол. 1996 оны 6 сар №13 (63)
2. Монгол Улсын Засгийн Газар. Төрийн мэдээлэл, №34, Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэлийн жагсаалт батлах тухай Засгийн Газрын тогтоол №140
3. Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2012-2016. http://politics.news.mn/content/118798.shtml

***Архивын материал -***

1. Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны Төв Архив. Х №112 Д№01 ХН№01
2. Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны Төв Архив.Х №112 Д№01 ХН№06
3. Гадаад Харилцааны Төв Архив СХ №3, Д№1, ХН №209

***Солонгос материал***

1. 외교통상부, "김대중대통령몽골국빈방문(1999.5.30.-6.1.울란바타르)" (1999.06) ; 『연합뉴스』 (1999.5.31).
2. 잔즈브도르쥔롬보, 몽골, 조선민주주의인민공화국관계 60 년 (60 years of Relations Between Mongolia and The Democratic People`s Republic of Korea), 2007. 평양, p-125-128.
3. "몽골노동부의외국인노동자현황" (http://www.rfa.org/korean/in_focus/ne-jw-07022013164635.html. 검색일: 2013 년 9 월 25 일).
4. 한국외교부, 『재외동포현황』
5. 남양주시몽골문화촌 http://www.mongoliatown.co.kr/ (검색일: 2014 년 05 월 20 일).
6. 서울의몽골울란바타르문화진흥원 http://www.mongolcenter.org/ (검색일: 2014 년 05 월 20 일).
7. 한국외국어대학몽골어학과 http://mongolian.hufs.ac.kr/ (검색일: 2014 년 05 월 20 일).
8. 외교통상부, "한·몽공동성명(노무현대통령과엥흐바야르대통령)"(울란바타르, 2006.05.09.).
9. "한・몽골 '선린우호협력동반자관계' 구축", 『연합뉴스』(2006, 5, 8).
10. 외교부동북아 3 과, 『몽골개황』 (2011.08), 120 쪽.
11. 외교부, 『몽골개황』(2011, 11, 8). 통계기준: 2010 년 4 월
12. 외교부동북아 3 과, "몽골약황"(2013, 07). 외교부, 『국가별재외동포현황』(2011), p. 7, p..
13. 외교부, 『재외동포단체현황』(2013).
14. 이성규, "한국과몽골의정치, 경제교류의현황과발전방안," 『앞의책』, p.17-18
15. 청와대정책브리핑, "한-몽골, 포괄적동반자관계격상: 정상회담갖고공동성명...에너지·자원분야 MOU 도" (2011 년 8 월 22 일), (http://www.korea.kr/policy/diplomacyView.do?newsId=148717034 검색일: 2013, 9, 23).
16. 청와대정책브리핑( 2011, 8, 22).
17. 청와대정책브리핑( 2011, 8, 22).